



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

### АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архивын тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмсүгэй:

16.4.Аймаг, нийслэлийн архивын эрхлэгчийг архив, түүх, нийгмийн салбарын мэргэжилтэй, архивын байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.”

2 дугаар зүйл. Архивын тухай хуулийн 16.3-ыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

16.3.Аймаг, нийслэлийн архивын эрхлэгчийг Үндэсний архивын газрын даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.” МОНГОЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ